



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМД

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2020.07.29 № 677

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Хандивын тайлангийн дүгнэлт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Говь-Алтай аймгийн Иргэний хөдөлгөөний намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Говь-Алтай аймгийн Иргэний хөдөлгөөний нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивыг тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

**Дүгнэлтийн үндэслэл**

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Говь-Алтай аймгийн Иргэний хөдөлгөөний намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт-4000, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/47 тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлтэй нийцэж буй эсэхийг дэмжих номлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

**Дүгнэлт**

Говь-Алтай аймгийн Иргэний хөдөлгөөний нам ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



07021057